



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 07

Хажуу шинэ-Ус

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар тогтоолоор батлагдсан “ Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажиллах журам”-ыг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн ээлжит есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг таван төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй байгуулахаар тогтоосугай.

2.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Зөвлөлийн тэргүүн: Б.Пүрэвсэнгэ (Сумын ИТХурлын дарга)
Л.Батбаатар (ИТХ-ын Төлөөлөгч)
М.Болортуяа (ИТХ-ын Төлөөлөгч)
П.Цэцэгмаа (ИТХ-ын Төлөөлөгч)
Т.Ариунаа (ИТХ-ын Төлөөлөгч)

3. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны шийдвэрийн биелэлтийг хангуулах, хуралдааны бэлтгэл ажлыг хангах, хороод ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах чиглэлээр идэвх санаачлага, үр дүнтэй ажиллахыг Хурлын зөвлөлд үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 33 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Б.ПҮРЭВСЭНГЭ